



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/409

Есөнбулаг

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 351 дүгээр зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх УТ2201011379001 (ЗГХЭГ/20240202025) дугаар бүхий Засаг даргын Тамгын газарт лед дэлгэц худалдан авах ажлыг "Лед мастер" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг аймгийн Тамгын газрын дарга (Ш.Эрдэнэбат)-т олгосугай.

2. Ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Э.Пүрэвжав)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

